

زىننىتىمىز

يىزىشقا كىرىش، بىر زىننىتىمىز

10700

يىزىشقا كىرىش، بىر زىننىتىمىز، يىزىشقا كىرىش، بىر زىننىتىمىز | يىزىشقا كىرىش، بىر زىننىتىمىز |

97000

• 0700

77000

• 6700

97000

• 77000

107000

• 70700

97000

• 97000

107000

• 107000

97000

• 97000

67000

• 7700

107000

• 97000

97000

• 07000

60700

• 67000

107000

• 77000

70700

• 70700

90700

• 97000

06700

• 107000



6670	<p>• 9000 • 9000</p> <p>• 7000</p>	<p>• 9000 • 9000</p> <p>• 7000</p>
7070	<p>• 9000 • 9000</p> <p>• 7000</p>	<p>• 9000 • 9000</p> <p>• 7000</p>
9070	<p>• 9000 • 9000</p> <p>• 7000</p>	<p>• 9000 • 9000</p> <p>• 7000</p>
0070	<p>• 9000 • 9000</p> <p>• 7000</p>	<p>• 9000 • 9000</p> <p>• 7000</p>
0070	<p>• 9000 • 9000</p> <p>• 7000</p>	<p>• 9000 • 9000</p> <p>• 7000</p>



ГАРЧИГ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

320.	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай /Шинэчилсэн найруулга/	2725
321.	Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2776
322.	Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай	2778
323.	Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2779
324.	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2782
325.	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай	2784
326.	Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2785
327.	Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2786
328.	Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	2791
329.	Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай	2793
330.	Улсын гэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2794
331.	Нийслэл хотын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2801

332.	Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		2803
333.	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай		2808
334.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай		2809
335.	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		2810
336.	Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай		2811
337.	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай		2812
338.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай		2813
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ			
339.	“Хот байгуулах тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 68	2814
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ			
340.	Журам батлах тухай	Дугаар 208	2816



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын тусгай болон бусад чиг үүргийг тогтоох, хөгжлийн бодлого, удирдлага, зохион байгуулалтын онцлог, дагуул хот, эдийн засгийн тусгай бүс, төрийн дээд болон төрийн захиргааны төв байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгж, хуулийн этгээд, байгууллагатай харилцахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын хууль тогтоомж

2.1.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль², энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдалтай холбогдсон энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн үндэс, зохион байгуулалт

4.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот /цаашид “нийслэл хот” гэх/ нь хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалттай эрх зүйн байдал бүхий хот мөн.

¹Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

²Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2021 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

4.2.Нийслэл нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана. Хороо нь хэсгийн зохион байгуулалттай байна.

4.3.Нийслэл хот нь дагуул хоттой байна.

5 дугаар зүйл.Нийслэл хотыг хөгжүүлэх бодлого

5.1.Нийслэл хотыг хөгжүүлэх бодлогыг тодорхойлоход Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн³ 5 дугаар зүйлд зааснаас гадна нийслэл хот нь нийгэм, соёлын амьдралын бүхий л хүрээнд тэргүүлэх байр суурь эзлэх нөхцөлийг бүрдүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зарчмыг баримтална.

5.2.Нийслэл хотын хот байгуулалт, төлөвлөлтийн бодлого нь үндэсний уран барилгын өв уламжлалыг орчин үеийн хотын хөгжлийн нийтлэг жишигтэй хослуулан хөгжүүлэхэд чиглэнэ.

5.3.Нийслэл хот нь нийслэл хотыг хөгжүүлэх бодлого, төлөвлөлтийн хүрээнд газар чөлөөлөх арга хэмжээг авч хэрэгжүүлэх бөгөөд шаардагдах хөрөнгийг улс, нийслэлийн төсөвт жил бүр тусгана.

6 дугаар зүйл.Нийслэлийн нутаг дэвсгэр болон нийслэл хотын эдэлбэр газар, бүсчлэл

6.1.Нийслэл нь Улсын Их Хурлаас баталсан хилийн цэс бүхий нутаг дэвсгэртэй байна.

6.2.Нийслэл хот нь хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгөөр тодорхойлогдож, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан тэг гортиг бүхий эдэлбэр газартай байна.

6.3.Энэ хуулийн 6.2-т заасан эдэлбэр газар нь бүсчлэлтэй байх бөгөөд эдэлбэр газрын бүсчлэл тогтоох шалгуур үзүүлэлтийг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн санал болгосноор Засгийн газар тогтооно.

6.4.Энэ хуулийн 6.3-т заасан шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн эдэлбэр газрын бүсчлэл, бүсчлэлийн дүрмийг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

³Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2020 оны 21 дугаарт нийтлэгдсэн.

6.5. Хотын төлөвлөлт, барилгажилтын норм, дүрэмд заасан хүн амын нягтралын хязгаарыг давсан газарт инженерийн болон нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж, нийтийн эзэмшлийн зам, талбай, ногоон байгууламж барихаас бусад зориулалтаар шинээр газар эзэмших, ашиглах эрх, барилга байгууламж барих зөвшөөрөл олгохгүй.

7 дугаар зүйл. Бэлгэ тэмдэг

7.1. Нийслэл хот бэлгэ тэмдэгтэй байна.

7.2. Нийслэл хотын бэлгэ тэмдгийн загвар, түүнийг хэрэглэх журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

ХОЁРДУГААР БҮЛЭГ НИЙСЛЭЛ ХОТЫН ЧИГ ҮҮРЭГ, ДҮРЭМ

8 дугаар зүйл. Нийслэл хотын чиг үүрэг

8.1. Нийслэл нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24.1-д зааснаас гадна нийслэл хот болохын хувьд энэ хуульд заасан тусгай болон бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.

8.2. Нийслэл хот нь дараах тусгай чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.2.1. Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Үндсэн хуулийн цэц, төрийн захиргааны болон төрийн бусад байгууллага, гадаад улсын Дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлэх;

8.2.2. хуульд өөрөөр заагаагүй бол үндэсний болон олон улсын хэмжээний баяр наадам, хурал, урлаг, спортын болон бусад арга хэмжээг зохион байгуулах;

8.2.3. олон улсын зорчигч болон ачаа тээвэр, логиستيкийн үйл ажиллагааны удирдлага, зохицуулалт;

8.2.4. нийслэл дэх үндэсний хэмжээний түүх, соёлын дурсгалт газрын хадгалалт, хамгаалалт;

8.2.5. нийслэлийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх олон улсын чанартай авто зам барих, түүний арчлалт, засвар, холбогдох үйл ажиллагаа;

8.2.6.нийслэл хотын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт;

8.2.7.энэ хуульд заасан нийслэл хотын тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай барилга байгууламж, авто зам, нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламж, гэрэлтүүлэг болон бусад дэд бүтцийн засвар, арчлалт, цэвэрлэгээ, үйлчилгээ, хамгаалалт.

8.3.Нийслэл хот нь дараах бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.3.1.нийслэлийг хөгжүүлэх сангийн менежмент;

8.3.2.нийслэлийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилт;

8.3.3.орчны аюулгүй байдал;

8.3.4.хүнсний хангамж, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хөтөлбөр, нийтлэг зохицуулалт;

8.3.5.хот, суурин газрын дахин төлөвлөлт;

8.3.6.нийслэлийн авто замын арчлалт, засвар, төлөвлөлт, хяналт;

8.3.7.хүн амын ундны болон ахуйн хэрэглээний төвлөрсөн усан хангамж;

8.3.8.нийслэлийн ус, дулааны төвлөрсөн бус инженерийн хангамж;

8.3.9.сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааны зохицуулалт, хяналт;

8.3.10.гадна болон явуулын зар сурталчилгааны зохицуулалт, хяналт;

8.3.11.авто замын түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, нийслэл хотод тулгамдсан бусад асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээ;

8.3.12.гадаадын зээл, тусламжаар нийслэлд хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний нийслэлийн хариуцах хөрөнгө, зээлийн хүүгийн төлбөр;

8.3.13.нийслэлийн нутаг дэвсгэр дэх голын хамгаалалт, тохижилт;

8.3.14. нийслэлийн нутаг дэвсгэр дэх дархан цаазат болон байгалийн цогцолбор, нөөц, дурсгалт газрыг иргэдийн аялах, амрах орчныг бүрдүүлэх зорилгоор тохижуулах, хамгаалах төсөл, арга хэмжээ;

8.3.15. хотын өөрийн мэдлийн орон сууцны ашиглалт, хуваарилалт;

8.3.16. хуульд заасан бусад.

8.4. Засгийн газар энэ хуулийн 8.2-т заасан тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төрийн өмчийг эзэмших, ашиглах эрхийг хууль тогтоомжид нийцүүлэн нийслэлд шилжүүлж болно.

9 дүгээр зүйл. Нийслэл хотын дүрэм

9.1. Хуулиар тусгайлан зохицуулаагүй асуудлыг нийслэл хотын дүрмээр зохицуулж болно.

9.2. Нийслэл хотын дүрмийг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

9.3. Нийслэл хотын дүрмийг олон нийтэд тайлбарлан таниулсны үндсэн дээр Захиргааны ерөнхий хуулийн⁴ 67.2-т заасны дагуу бүртгүүлснээс хойш гурваас доошгүй сарын дараа дагаж мөрдүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ НИЙСЛЭЛ ХОТЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦАА

10 дугаар зүйл. Нийслэл хотын эдийн засгийн үндэс

10.1. Нийслэл хотын эдийн засгийн үндэс нь улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө, түүнчлэн нийслэлийн өмч, татварын болон татварын бус орлого, нийслэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөс бүрдэнэ.

10.2. Нийслэл хотын эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх, бие даан хөгжих баталгаагаар хангах нь төрийн үүрэг бөгөөд энэ харилцааг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

⁴Захиргааны ерөнхий хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

11 дүгээр зүйл.Нийслэлийн төсөв

11.1.Нийслэл нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16.1-д заасны дагуу бие даасан төсөвтэй байна.

11.2.Энэ хуулийн 8.2-т заасан тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг улсын болон орон нутгийн төсвөөс, 8.3-т заасан бусад чиг үүргийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

12 дугаар зүйл.Нийслэлийн өмч

12.1.Нийслэл өмчтэй байна.

12.2.Нийслэлийн өмч нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24.1 дэх хэсэг, энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор хуульд заасны дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах хөрөнгө болно.

12.3.Энэ хуулийн 8.2-т заасан тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төрийн өмчийн өмчлөх эрхийг хууль тогтоомжид заасны дагуу нийслэлд шилжүүлж болно.

13 дугаар зүйл.Нийслэлийн үнэт цаас

13.1.Нийслэл хуульд заасан нөхцөл, журмын дагуу үнэт цаас гаргаж болно.

13.2.Нийслэлийн үнэт цаас гаргах асуудлыг Өрийн удирдлагын тухай хууль⁵ болон холбогдох бусад хуулиар зохицуулна.

14 дүгээр зүйл.Концесс олгох

14.1.Нийслэлд концессын гэрээгээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг Концессын тухай хуулийн⁶ дагуу зохицуулна.

15 дугаар зүйл.Нийслэлийн өмчит хуулийн этгээд

15.1.Нийслэл нь орон нутгийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдтэй байж болно.

⁵Өрийн удирдлагын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 9 дугаарт нийтлэгдсэн.

⁶Концессын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 9 дугаарт нийтлэгдсэн.

15.2.Нийслэлийн болон нийслэл хотын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой хувийн өмчийн хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх боломжгүй ажил үйлчилгээг энэ хуулийн 15.1-д заасан хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

16 дугаар зүйл.Нийслэл хотын албан татвар

16.1.Нийслэл хот албан татвартай байх бөгөөд албан татварыг хуулиар тогтооно.

16.2.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь татварын хууль тогтоомжоор эрх олгож, тогтоосон хязгаарын хүрээнд албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтооно.

17 дугаар зүйл.Нийслэлийг хөгжүүлэх сан

17.1.Нийслэл нь нийслэлийг хөгжүүлэх сантай байж болно. Нийслэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг дараах үйл ажиллагаанд зарцуулна:

- 17.1.1.хотын стандарт, соёлыг хөгжүүлэх;
- 17.1.2.ухаалаг, цахим хотын хөгжлийг дэмжих;
- 17.1.3.үйлдвэрлэл, инновацыг дэмжих;
- 17.1.4.хөрөнгө оруулалтыг дэмжих;
- 17.1.5.төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих;
- 17.1.6.хот байгуулалт, дэд бүтцийг хөгжүүлэх;
- 17.1.7.ногоон хөгжлийг дэмжих;
- 17.1.8.аялал жуулчлалыг хөгжүүлэх;
- 17.1.9.эрсдэлийг бууруулах.

17.2.Энэ хуулийн 17.1-д заасан сангийн хөрөнгө нь нийслэлийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.

17.3.Энэ хуулийн 17.1-д заасан сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж, түүний хэрэгжилтэд хяналт тавина.

17.4.Нийслэлийг хөгжүүлэх сангаас зээл олгох, өр, авлага үүсгэхийг хориглоно.

18 дугаар зүйл.Нийслэл хот дахь хөрөнгө оруулалт

18.1.Хөрөнгө оруулалтын тухай хуулийн⁷ 3.1.2-т заасан этгээд нийслэлийн өмчит ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийн хөрөнгөд биет болон биет бус хэлбэрээр хөрөнгө оруулалт хийж болно.

⁷Хөрөнгө оруулалтын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2013 оны 41 дугаарт нийтлэгдсэн.

18.2.Энэ хуулийн 18.1-д заасны дагуу ирүүлсэн хөрөнгө оруулалт хийх саналыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний эрх олгосноор нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч шийдвэрлэнэ.

19 дүгээр зүйл.Нийслэл хот дахь хөрөнгө оруулалтыг дэмжих

19.1.Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж байгаа хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэдгээртэй хамтран ажиллаж нийслэл хотыг хөгжүүлэх зорилгоор Хөрөнгө оруулагчдын зөвлөлийг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн дэргэд байгуулна.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан зөвлөл нь орон тооны бус байх ба зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч батална.

19.3.Нийслэл хотын удирдлага энэ хуулийн 18.2-т заасны дагуу хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулагчийг дараах баталгаагаар хангана:

19.3.1.энэ хуулийн 18.2-т заасан шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох, цуцлах асуудлыг шийдвэрлэхдээ Захиргааны ерөнхий хуульд заасан журам, үндэслэлийг баримтлах;

19.3.2.хөрөнгө оруулалттай холбоотой мэдээллээр хангах;

19.3.3.хуульд өөрөөр заагаагүй бол газар эзэмшүүлж, ашиглуулах шийдвэрээ өөрчлөхгүй байх;

19.3.4.хөрөнгө оруулалттай холбоотой үйл ажиллагаанд хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох;

19.3.5.хуульд заасан бусад.

19.4.Нийслэл хотын удирдлага хуульд өөрөөр заагаагүй бол нийслэл хот дахь хөрөнгө оруулалтыг үр өгөөжтэй байлгах үүднээс энэ хуулийн 18.1-д заасан хөрөнгө оруулалт авсан хуулийн этгээдийг дараах баталгаагаар хангана:

19.4.1.ажиллах цагийн хуваарийг уян хатан шийдвэрлэх;

19.4.2.нийтийн ашиг сонирхлын үүднээс хөрөнгө оруулалтын төрөл, хэлбэр, зорилгоос хамаарч холбогдох журамд заасан зардлын санхүүжилтийг олгох;

19.4.3.хуульд заасан бусад.

19.5.Нийслэл хотын удирдлага энэ хуулийн 19.3, 19.4-т заасан баталгаагаар хангах асуудлыг шийдвэрлэхдээ Захиргааны ерөнхий хуулийн 42 дугаар зүйлд заасан сонгох боломжийг хэрэглэнэ.

19.6.Нийслэл хот дахь хөрөнгө оруулагчийг энэ хуулийн 19.3, 19.4-т заасан баталгаагаар хангах эсэхийг сонгохдоо нийслэл хотын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг шалгуур болгож, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түүний саналыг үндэслэн шийдвэрлэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ НИЙСЛЭЛ ХОТЫН УДИРДЛАГА, ТҮҮНИЙ БҮРЭН ЭРХ

20 дугаар зүйл.Нийслэл хотын удирдлага, түүний онцлог

20.1.Нийслэл хотын удирдлага дараах тогтолцоотой байна:

20.1.1.нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;

20.1.2.нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч.

20.2.Нийслэлийн Засаг дарга нь Улаанбаатар хотын Захирагч байх бөгөөд ажлын албатай байна.

20.3.Нийслэл хотын удирдлага шийдвэр гаргахдаа Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийг баримтална.

20.4.Засгийн газар нийслэл, дүүргийн захиргааны байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын ангилал, зэрэглэлийг нутгийн захиргааны бусад адилтгах албан тушаалын ангилал зэрэглэлээс өөрөөр тогтоож болно.

21 дүгээр зүйл.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

21.1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.1.1.энэ хуулийн 8.2-т заасан тусгай чиг үүргийн хэрэгжилтийн талаарх нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн тайланг сонсох;

21.1.2.энэ хуулийн 8.3-т заасан бусад чиг үүрэгт хамаарах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, хэрэгжилтийн талаарх нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн тайланг дүгнэх;

21.1.3.нийслэл хотын чиг үүргийг хэрэгжүүлэх талаар хуульд нийцүүлэн дүрэм, журам, стандарт, заавар батлах;

21.1.4.нийслэл хотын болон нийтийн эдэлбэр газар, түүний хэмжээ, ашиглалтын журмыг тогтоох;

21.1.5.хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд нийслэл хотын эдэлбэр газрын бүсчлэл, үйлчилгээний төрөл, хэлбэр, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах зардал зэргийг харгалзан албан татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох;

21.1.6.хуульд заасан бусад.

22 дугаар зүйл.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн бүрэн эрх

22.1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

22.1.1.энэ хуулийн 8.2-т заасан тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг Засгийн газрын өмнө хариуцаж, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах;

22.1.2.энэ хуулийн 8.3-т заасан бусад чиг үүрэгтэй холбогдох тооцоо, судалгаа бүхий шийдвэрийн төсөл боловсруулж, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх;

22.1.3.энэ хуулийн 22.1.2-т заасан асуудлаар нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг хариуцах;

22.1.4.хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд Засгийн газарт санал тавих, Засгийн газрын хуралдаанд оролцох;

22.1.5.хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд хуулийн төсөл санаачлахаас бусад асуудлаар Засгийн газрын шийдвэрийн төслийг холбогдох журмын дагуу санаачлан

боловсруулж, Засгийн газрын хуралдаанд оруулж, танилцуулах, хэлэлцүүлэх;

22.1.6.нийслэл хотыг хөгжүүлэх асуудлаар төсөл, хөтөлбөр санаачлах, төсөл, хөтөлбөрт санал, дүгнэлт өгөх, тухайн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Засгийн газраас дэмжлэг хүсэх;

22.1.7.нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулснаар нийслэл хотын дагуул хотын Захирагчийг томилох, чөлөөлөх;

22.1.8.нийслэлийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын ажиллах цагийн хуваарийг тогтоож, мөрдүүлэх;

22.1.9.дотоод, гадаадад нийслэлийг төлөөлөх;

22.1.10.гадаад улсад нийслэл хотыг төлөөлөх этгээдийг томилох, чөлөөлөх;

22.1.11.зөвлөх эрх бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөл байгуулах, түүний бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах;

22.1.12.Улаанбаатар хотын Ерөнхий менежерт хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх бүрэн эрхээ шилжүүлэх;

22.1.13.хуульд заасан бусад.

22.2.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24.1.7, 24.1.9, 24.1.11, 24.1.12, 24.1.13, 24.1.14, 24.1.15, 24.1.16, 24.1.17, 24.1.18, 24.1.19, 24.1.21, 24.1.22, энэ хуулийн 8.3.3, 8.3.4, 8.3.6, 8.3.7, 8.3.8, 8.3.9, 8.3.10, 8.3.11, 8.3.12-т заасан чиг үүргээ хэрэгжүүлэх бүрэн эрхээ Улаанбаатар хотын Ерөнхий менежерт гэрээний үндсэн дээр шилжүүлж болно.

22.3.Энэ хуулийн 22.2-т заасан гэрээнд нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас шилжүүлэх бүрэн эрхийн хүрээ, хязгаар, тайлагнах, хяналт тавих журмыг тусгана.

22.4.Энэ хуулийн 22.2-т заасны дагуу бүрэн эрхээ шилжүүлсэн нь нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

22.5.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч бүрэн эрхийнхээ хүрээнд захирамж гаргана.

23 дугаар зүйл.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн бүрэн эрхийн баталгаа

23.1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Засгийн газрын гишүүнтэй адил баталгаагаар хангагдана.

24 дүгээр зүйл.Улаанбаатар хотын Ерөнхий менежер, түүний бүрэн эрх

24.1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нь нийслэл хотын аж ахуйн чиг үүргийг хэрэгжүүлэх, нэгдмэл байдлыг хангах, холбогдох байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий Улаанбаатар хотын Ерөнхий менежер /цаашид “Ерөнхий менежер” гэх/-ийг томилж, чөлөөлнө.

24.2.Ерөнхий менежер ажлаа нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн өмнө хариуцна.

24.3.Ерөнхий менежер дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

24.3.1.хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах ажлыг зохион байгуулах;

24.3.2.хотын аж ахуйн асуудал хариуцсан байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

24.3.3.хотын аж ахуйн асуудлаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээний үндсэн дээр хамтран ажиллах;

24.3.4.нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн олгосон эрх хэмжээний хүрээнд хотын аж ахуйн асуудлаар дүүргийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, үүрэг өгөх;

24.3.5.Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны ажилтан, албан хаагчийг томилж, чөлөөлөх;

24.3.6.хуульд заасан бусад.

24.4.Ерөнхий менежер энэ хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд дүүргийн Засаг даргатай шууд харилцана.

24.5.Хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиглэлээр Ерөнхий менежерийн өгсөн үүргийг холбогдох албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд биелүүлнэ.

24.6.Ерөнхий менежер эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргах бөгөөд хуульд заасан журмын дагуу тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

25 дугаар зүйл.Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба

25.1.Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, орон тооны хязгаарыг Улаанбаатар хотын Захирагчийн санал болгосноор Засгийн газар тогтооно.

25.2.Улаанбаатар хотын Захирагч өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлэх хотын аж ахуйн асуудал хариуцсан газартай байх бөгөөд түүнийг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.

25.3.Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба нь нийслэлийн Засаг даргын ажлын албанаас тусдаа байна. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дарга нь Ерөнхий менежер байна.

25.4.Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

25.4.1.Улаанбаатар хотын Захирагчид мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах;

25.4.2.Улаанбаатар хотын Захирагчийг шаардлагатай мэдээллээр хангах;

25.4.3.нийслэл хотын аж ахуйн асуудлыг судлах, шийдвэрийн төслийг боловсруулах, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

25.4.4.иргэн, хуулийн этгээдэд хотын нийтийн аж ахуйн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

25.4.5.хуульд заасан бусад.

**ТАВДУГААР БҮЛЭГ
НИЙСЛЭЛ ХОТЫН УДИРДЛАГА БУСАД ЭТГЭЭДТЭЙ ХАРИЛЦАХ**

**26 дугаар зүйл.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
Засгийн газар, төрийн захиргааны төв
байгууллагатай харилцах**

26.1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагатай харилцана.

**27 дугаар зүйл.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар
хотын Захирагч Засгийн газартай харилцах**

27.1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Засгийн газартай дараах журмаар харилцана:

27.1.1.Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангах;

27.1.2.хуульд заасан чиг үүрэгтэй холбоотой асуудлаар Засгийн газарт санал тавих, Засгийн газрын хуралдаанд оролцох, байр сууриа илэрхийлэх, хууль санаачлахаас бусад өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг санаачлах, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнтэй шууд харилцах.

**28 дугаар зүйл.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар
хотын Захирагч төрийн захиргааны төв байгууллагатай
харилцах**

28.1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нийслэл хотын эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор эрхлэх асуудлыг хамаарах төрийн захиргааны төв байгууллагатай хамтарсан шийдвэр гаргаж, биелэлтийг зохион байгуулна.

28.2.Төрийн захиргааны төв байгууллага нь Захиргааны ерөнхий хуулийн 61, 62 дугаар зүйлд заасан шаардлагыг үндэслэн салбарын болон салбар хоорондын шийдвэр гаргахдаа нийслэл хот, түүний оршин суугчийн нийтлэг эрх ашигт хамаарах асуудлаар нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн саналыг авсан байна.

28.3.Нийслэл хотыг энэ хуульд заасан тусгай чиг үүргээ хэрэгжүүлэхэд эрхлэх асуудлыг хамаарах төрийн захиргааны төв байгууллага дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

28.4.Холбогдох хуульд заасны дагуу төрийн захиргааны төв байгууллага нийслэлийн нутаг дэвсгэрт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах тухай шийдвэр гаргахдаа хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, эдэлбэр газрын бүсчлэлийн дүрэмд нийцүүлэн нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн саналыг авсан байна.

29 дүгээр зүйл.Нийслэл хотын удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгж, улсын зэрэглэлтэй хоттой харилцах

29.1.Нийслэл хотын удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгж, улсын зэрэглэлтэй хотын удирдлагатай нийслэл хотын эдийн засаг, нийгмийн асуудлаар хамтран ажиллаж болно.

29.2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгж, улсын зэрэглэлтэй хотын удирдлага нийслэл хотын хүн амыг бараа, үйлчилгээгээр хангах, нийслэлд үндэсний их баяр наадам, төрийн ёслол хүндэтгэл, улсын болон олон улсын арга хэмжээ зохион явуулахад хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн дагуу дэмжлэг үзүүлнэ.

29.3.Нийслэл хотыг хөгжүүлэх, нийгэм эдийн засгийн үндсийг бүрдүүлэх зорилгоор үйлдвэр, аж ахуй, хангамжийн байгууллагыг Засгийн газрын шийдвэрээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгжийн нутаг дэвсгэрт байгуулж, гэрээний үндсэн дээр ашиглаж болно.

30 дугаар зүйл.Нийслэл хотын удирдлагаас дүүргийн удирдлагатай харилцах

30.1.Нийслэл хотын тусгай чиг үүргийг хэрэгжүүлэхэд дүүргийн удирдлага туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

30.2.Дүүрэг хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд гэнэтийн болон давагдашгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийслэл хотоос хүний нөөц, техник, эдийн засгийн туслалцаа үзүүлнэ.

30.3.Нийслэл нь чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах өмчийг хуульд заасны дагуу дүүрэгт шилжүүлэх, эсхүл дүүргээс шилжүүлэн авч болно.

30.4.Нийслэл хотын удирдлага дүүргийн оршин суугчдын нийтлэг эрх ашигт хамаарах асуудлаар шийдвэр гаргахдаа тухайн дүүргийн удирдлагын саналыг авсан байна.

30.5.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нь дүүргийн Засаг даргын санал, хүн амын тоо, үйлчилгээний хүртээмжийг харгалзан дүүргийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай саналыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

31 дүгээр зүйл.Аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах

31.1.Нийслэлийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж болох бөгөөд энэ харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

31.2.Нийслэл хотын удирдлага энэ хуулийн 8.2, 8.3-т заасан зарим чиг үүргээ холбогдох хуульд заасны дагуу гэрээний үндсэн дээр хувийн өмчит хуулийн этгээдээр гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн, эсхүл хэсэгчлэн санхүүжүүлж болно.

31.3.Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд нь өмчийн хэлбэрээс үл хамааран хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хотын стандартыг мөрдөх, нийслэл хотын удирдлагаас хуульд нийцүүлэн гаргасан шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.

32 дугаар зүйл.Нийслэл хотын оршин суугчийн эрх, үүрэг

32.1.Нийслэл хотын оршин суугч Монгол Улсын Үндсэн хууль бусад хуульд заасан үндсэн эрх, эрх чөлөөг эдлэхээс гадна дараах эрхтэй:

32.1.1.нийслэл хотын удирдлагын шийдвэрийн талаар мэдээлэл авах;

32.1.2.хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, эдэлбэр газрын бүсчлэлийн дүрэм боловсруулахад санал өгөх, хэрэгжүүлэхэд оролцох;

32.1.3.нийслэл хотын нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар санал гаргах, хувь нэмэр оруулах;

32.1.4.хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, бүсчлэлд заасан суурьшлын бүсэд оршин суугаа бол дэд бүтцийн үйлчилгээгээр хангагдах;

32.1.5.хуульд заасан бусад.

32.2.Нийслэл хотын оршин суугч дараах үүрэгтэй:



32.2.1.нийслэл хотын удирдлагаас гаргасан шийдвэрийг биелүүлэх;

32.2.2.хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд заасан суурьшлын бүсэд оршин суух;

32.2.3.нийслэл хотын дүрэм, стандартыг дагаж мөрдөх;

32.2.4.нийтийн эзэмшлийн эд зүйлийг зохистой ашиглах, орчныг цэвэр байлгах;

32.2.5.хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, бүсчлэлийн дүрмийн дагуу орон байр, орчноо тохижуулах;

32.2.6.хуульд заасан бусад.

32.3.Нийслэл хотод зорчигч этгээд энэ хууль, бусад хууль тогтоомж, нийслэл хотын удирдлагаас хуульд нийцүүлэн гаргасан шийдвэрийг сахин биелүүлэх үүрэгтэй.

33 дугаар зүйл.Нийслэл хотыг хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжих

33.1.Нийслэл хотын хөгжилд дараах чиглэлээр хувь нэмэр оруулсан иргэн, хуулийн этгээдийг шалгаруулж, урамшуулна:

33.1.1.ногоон байгууламжийг нэмэгдүүлэх;

33.1.2.орчноо тохижуулах, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг засаж сайжруулах;

33.1.3.орчны аюулгүй байдлыг хангах;

33.1.4.замын түгжрэл, хог хаягдал, орчны бохирдол, тулгамдсан бусад асуудлыг шийдвэрлэх;

33.1.5.хуульд заасан бусад.

33.2.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 33.1-д заасны дагуу хувь нэмэр оруулж, үр дүнд хүрсэн иргэн, хуулийн этгээдийг шалгаруулах, дэмжих, урамшуулах журмыг батална.

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ
НИЙСЛЭЛ ХОТЫН ДАГУУЛ ХОТ, ЭДИЙН ЗАСГИЙН
ТУСГАЙ БҮС**

**34 дүгээр зүйл.Нийслэл хотын дагуул хот, түүний зохион
байгуулалтын үндэс**

34.1.Нийслэл хотын дагуул хот /цаашид “дагуул хот” гэх/ нь нийслэл хоттой эдэлбэр газар, хүн ам, эдийн засаг, дэд бүтэц, тээвэр, логистикийн нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, газар зүйн байрлал болон нийслэл хотын тусгай чиг үүргийг гүйцэтгэхэд стратегийн ач холбогдолтой, хот бүрдүүлэгч дэд бүтэц бүхий төвлөрсөн суурин газар мөн.

34.2.Дагуул хотыг нийслэлийн болон бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид, эсхүл засаг захиргааны нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжид дамнан байгуулж болно.

34.3.Дагуул хотын эдэлбэр газрыг улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын эдэлбэр газартай давхардуулан олгож үл болно.

34.4.Дагуул хот дүрэмтэй байна. Хуулиар зохицуулснаас бусад дагуул хоттой холбоотой асуудлыг Засгийн газраас баталсан дүрмээр зохицуулна.

35 дугаар зүйл.Дагуул хотыг байгуулах

35.1.Дагуул хотыг стратегийн ач холбогдол бүхий дараах нөхцөлийг харгалзан Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал байгуулна:

35.1.1.улс, нийслэл болон тухайн орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх үр нөлөө;

35.1.2.аялал жуулчлал, соёлын үйлчилгээ, үйлдвэрлэлийн ач холбогдол;

35.1.3.үндэсний болон олон улсын тээвэр, логистик болох газар зүйн байрлал;

35.1.4.олон улсын харилцаа, худалдаа, үйлдвэрлэлийн сүлжээ болох дэд бүтэц;

35.1.5.хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар нийслэл хотын төвлөрлийг сааруулахад үзүүлэх нөлөө;

35.1.6. шинжлэх ухаан, инновац, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг төрөлжүүлэн хотхон хэлбэрээр хөгжүүлэх боломж.

35.2. Дагуул хотыг байгуулах шийдвэрт хотын нэр, эдэлбэр газрын хэмжээ, байршлыг тусгана.

36 дугаар зүйл. Дагуул хотын чиг үүрэг

36.1. Дагуул хотын чиг үүрэгт дараах асуудал хамаарна:

36.1.1. нийслэл хотын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилт;

36.1.2. хот тохижилт, олон нийтийн амралт, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалт;

36.1.3. унд, ахуйн хэрэгцээний ус хангамж;

36.1.4. авто замын арчлалт, хамгаалалт;

36.1.5. авто зогсоолын төлөвлөлт, арчлалт, хамгаалалт;

36.1.6. орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ;

36.1.7. хөшөө дурсгалын арчлалт, хамгаалалт;

36.1.8. гэрэлтүүлгийн арчлалт, хамгаалалт;

36.1.9. хуульд заасан бусад.

36.2. Дагуул хот шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 8.2, 8.3-т заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

37 дугаар зүйл. Дагуул хотын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа явуулах баталгаа

37.1. Дагуул хотын удирдлага нь Захирагч, түүнд зөвлөх үүрэг бүхий дагуул хотын зөвлөлөөс бүрдэнэ.

37.2. Дагуул хотын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлж зохион байгуулах үүргийг дагуул хотын Захирагч гүйцэтгэнэ. Дагуул хотын Захирагчийг нээлттэй сонгон шалгаруулалт, сонсголын үндсэн дээр нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч томилно.

37.3. Дагуул хотын зөвлөл 7-11 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд зөвлөлийн гишүүнийг тухайн дагуул хот байрлах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, дагуул хотын нийгэм, эдийн засагт нөлөө бүхий хуулийн этгээдийн төлөөлөл, оршин суугчдаас нээлттэй сонгон шалгаруулж, томилно. Дагуул хотын Захирагч нь дагуул хотын зөвлөлийн дарга байна.



37.4. Дагуул хотын зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулах болон ажиллах журмыг дагуул хотын Захирагч батална.

37.5. Дагуул хотын Захирагч ажлын албатай байх бөгөөд ажлын албаны бүтэц, орон тооны хязгаарыг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч батална.

37.6. Дагуул хотын Захирагчийн ажлын албаны төсвийг нийслэлийн төсөвт тусгайлан тусгаж батална.

37.7. Энэ хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд дагуул хотын Захирагч захирамж гаргах бөгөөд хуульд заасан журмын дагуу тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

38 дугаар зүйл. Нийслэл хотын эдийн засгийн тусгай бүс

38.1. Нийслэл хот нь эдийн засгийн тусгай бүс /цаашид “тусгай бүс” гэх/-тэй байж болно. Тусгай бүсийг дагуул хотод Засгийн газрын шийдвэрээр байгуулна.

38.2. Нийслэл хот нь таваас илүүгүй тусгай бүстэй байж болно.

39 дүгээр зүйл. Тусгай бүс байгуулах чиглэл

39.1. Тусгай бүсийг үйл ажиллагааны дараах чиглэлээр дагнан, эсхүл хослуулж байгуулж болно:

- 39.1.1. мэдээлэл технологи, инновац;
- 39.1.2. аялал жуулчлал, соёл амралт;
- 39.1.3. хүлэмж, агуулахын аж ахуй;
- 39.1.4. хөнгөн болон хүнсний үйлдвэрлэл;
- 39.1.5. агаарын хөлгийн засвар, үйлчилгээ, угсралт.

Тайлбар: -Энэ хуулийн 39.1.4-т заасан хөнгөн болон хүнсний үйлдвэрлэл гэдэгт согтууруулах ундаа болон тамхины үйлдвэрлэл хамаарахгүй.

40 дүгээр зүйл. Тусгай бүс байгуулах нутаг дэвсгэр, байршил, төлөвлөгөө

40.1. Тусгай бүс байгуулах газар нутгийн хэмжээ, байршлыг Засгийн газар тогтооно.

40.2. Тусгай бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.



40.3.Энэ хуулийн 40.2-т заасан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд дараах асуудлыг тусгана:

- 40.3.1.тусгай бүсийг хөгжүүлэх хөтөлбөр;
- 40.3.2.газар, дэд бүтцийн хөтөлбөр;
- 40.3.3.хүн амыг суурьшуулах эсэх.

40.4.Тусгай бүсэд хүн амыг суурьшуулахгүй тохиолдолд тусгай бүсийн Захирагч нь уг асуудлыг тухайн засаг захиргааны нэгжийн удирдлагатай хамтран шийдвэрлэнэ.

40.5.Тусгай бүсэд газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг аж ахуйн нэгжид нээлттэй дуудлага худалдаагаар болон төсөл сонгон шалгаруулалтаар олгоно.

41 дүгээр зүйл.Тусгай бүсийн Захирагч

41.1.Тусгай бүсийн Захирагч нь тухайн тусгай бүс орших дагуул хотын Захирагч байна.

42 дугаар зүйл.Тусгай бүсэд үзүүлэх татварын дэмжлэг

42.1.Тусгай бүсэд байнга байрлаж, тогтвортой үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжид үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс нь дараах төрлийн татварын дэмжлэгийг үзүүлж болно:

- 42.1.1.газрын төлбөр;
- 42.1.2.үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар;
- 42.1.3.нийслэл хотын албан татвар.

42.2.Энэ хуулийн 42.1-д заасан татварын дэмжлэгийг холбогдох татварын хууль тогтоомжоор зохицуулна.

43 дугаар зүйл.Тусгай бүсэд үзүүлэх татварын бус дэмжлэг

43.1.Тусгай бүсэд байнга байрлаж, тогтвортой үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгжид үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс нь дараах татварын бус дэмжлэгийг үзүүлж болно:

43.1.1.цахилгаан, дулаан, түрээсийн төлбөр зэрэг урсгал зардалд тодорхой хэмжээгээр дэмжлэг үзүүлэх;

43.1.2.бизнес эрхлэхэд шаардагдах баримт бичиг, зөвшөөрөл, шаардлагуудыг хялбаршуулах;

43.1.3.жигж, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх хөнгөлөлттэй зээлийг тэргүүн ээлжид олгох.

43.2.Тусгай бүсэд үйл ажиллагаа эрхлэх аж ахуй нэгжийг урамшуулах, татварын бус дэмжлэг үзүүлэх асуудлыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан журмаар зохицуулна.

44 дүгээр зүйл.Тусгай бүс дэх дэд бүтэц

44.1.Тусгай бүс дэх дэд бүтцийг энэ хуулийн 40.3.2-т заасны дагуу төлөвлөн хөгжүүлнэ.

44.2.Тусгай бүсийн дэд бүтцийг улсын болон орон нутгийн төсөв, нийслэлийн үнэт цаас, нийслэлийг хөгжүүлэх сан, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлж болно.

44.3.Саарал ус ашиглах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, сэргээгдэх эрчим хүч бүхий эко дэд бүтэц байгуулахад энэ хуульд заасан татварын болон татварын бус дэмжлэг үзүүлж болно.

45 дугаар зүйл.Тусгай бүс дэх аж ахуйн нэгжийн бүртгэл

45.1.Тусгай бүсэд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж дагуул хотын ажлын албанд дараах баримт бичгийг бүрдүүлэн бүртгүүлнэ:

45.1.1.Монгол Улсын хуулийн этгээд бол өргөдөл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, бүртгэлийн хураамж төлсөн баримт;

45.1.2.гадаад улсын хуулийн этгээд бол өргөдөл, гадаад улсын хуулийн этгээдийг гэрчилсэн баримт бичгийн хуулбар, итгэмжлэл, бүртгэлийн хураамж төлсөн баримт.

45.2.Тусгай бүсийн Захирагчийн ажлын алба энэ хуулийн 45.1-д заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор хянаж, холбогдох журамд заасан шаардлага хангасан гэж үзвэл тусгай бүс дэх хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгох ба уг гэрчилгээ нь зөвхөн тухайн тусгай бүсэд хүчин төгөлдөр үйлчилнэ.

45.3.Тусгай бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийг дараах үндэслэлээр тусгай бүс дэх хуулийн этгээдийн бүртгэлээс хасна:

45.3.1.тусгай бүс дэх хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээ олгосон өдрөөс хойш нэг жилийн хугацаанд гэрээ, дүрэмд заасан үндсэн үйлдвэрлэл, үйлчилгээг эхлүүлээгүй бол;

45.3.2.үйл ажиллагаагаа эхлүүлсэн боловч дараалсан 12 сараас дээш хугацаагаар үйл ажиллагаа нь өөрөөс хамаарах шалтгаанаар тасалдсан, зогссон бол;

45.3.3.татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан бол.

ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД

46 дугаар зүйл.Нийслэл хотын үйл ажиллагааны ил тод байдал

46.1.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд⁸ заасны дагуу Нийслэл хотын удирдлагын шийдвэр, нийслэлийн төсөв, үйл ажиллагаа ил тод, нээлттэй байх бөгөөд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор цахим хуудаст байршуулж, олон нийтийг танилцах боломжоор хангана.

47 дугаар зүйл.Нийслэл хотын гадаад хамтын ажиллагаа

47.1.Нийслэл хот нь гадаад улсын нийслэл болон бусад хот, олон улсын байгууллагатай хууль тогтоомжид заасан хүрээнд дараах хэлбэрээр хамтран ажиллана:

47.1.1.хамтын ажиллагааны гэрээ байгуулах;

47.1.2.олон улсын хотуудын холбоог үүсгэн байгуулах, гишүүнээр элсэх;

47.1.3.нийслэл хотын суурин төлөөлөгч харилцан солилцох;

47.1.4.хуульд заасан бусад.

47.2.Нийслэл хот энэ хуулийн 47.1-д заасан гадаад хамтын ажиллагааг хэрэгжүүлэхдээ гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авна.

48 дугаар зүйл.Нийслэл хотын өдөр, шагнал

48.1.Нийслэл хотын өдрийг жил бүр тэмдэглэнэ.

48.2.Нийслэл хотыг хөгжүүлэх үйлсэд онцгой хувь нэмэр оруулсан иргэнийг “Нийслэл хотын хүндэт иргэн”-д өргөмжлөх болон бусад

⁸Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 26 дугаарт нийтлэгдсэн.

шагналаар шагнана. “Нийслэл хотын хүндэт иргэн”-д өргөмжлөх асуудлыг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн өргөн мэдүүлснээр нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэнэ.

48.3.“Нийслэл хотын хүндэт иргэн”-д өргөмжлөх болон бусад шагналаар шагнах журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

49 дүгээр зүйл.Нийслэл хотын судалгааны байгууллага

49.1.Нийслэл хотын хөгжлийн түүх, хэтийн төлөв, хотжилт, хот байгуулалт, хүн ам, хүрээлэн байгаа орчны талаар тулгамдаж байгаа асуудлыг судлах чиг үүрэг бүхий судалгаа, шинжилгээний төв нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн дэргэд ажиллана.

50 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

50.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд⁹ заасан хариуцлага хүлээлгэнэ.

50.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль¹⁰, эсхүл Зөрчлийн тухай хуульд¹¹ заасан хариуцлага хүлээлгэнэ.

51 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

51.1.Энэ хуулийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХуйН ЗӨВӨӨСӨН ХӨДӨӨ АЖ АХуйН ХАМГААГАХ АЖ АХуйН ЗӨВӨӨСӨН
МОНГОЛЫН ХӨДӨӨ АЖ АХуйН ЗӨВӨӨСӨН ХӨДӨӨ АЖ АХуйН ХАМГААГАХ АЖ АХуйН ЗӨВӨӨСӨН

60. Кэригэн Хонгор, Мэргэжлийн Зөвлөл

61. Мэргэжлийн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл

62. Хөдөө Аж Ахуйн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл

63. Мэргэжлийн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл
64. Мэргэжлийн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл

65. Хөдөө Аж Ахуйн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл

66. Хөдөө Аж Ахуйн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл

67. Хөдөө Аж Ахуйн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл

68. Хөдөө Аж Ахуйн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл

69. Хөдөө Аж Ахуйн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл

70. Хөдөө Аж Ахуйн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл
71. Хөдөө Аж Ахуйн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл

72. Хөдөө Аж Ахуйн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл

73. Хөдөө Аж Ахуйн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл

74. Хөдөө Аж Ахуйн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл

75. Хөдөө Аж Ахуйн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл

76. Хөдөө Аж Ахуйн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл, Хөдөө Аж Ахуйн Зөвлөл

61а КӨНН ХАВЦАА .. НЭГЭЙН ХӨГЖӨМӨР ХӨРӨНГӨН ХӨЙШӨ

61б . 6 . АНГАМ НЭГЭЙН ДЭН 01001 АМА 6 Ө КӨНН БЭРЭН А ДАМ 6 - Ө АНГАМ АМА АНГАМ ХӨНӨШӨ ХӨМӨӨН А ..

ХӨМӨӨННӨ ХӨМӨӨР АМ

ХӨН А НЭМЭХ АМ ХӨМӨӨН А

НЭМ . ХӨМӨӨННӨГӨН А

ХӨРӨНГӨМӨР АМАМАА :

- 6 . ХӨРӨННӨ ХӨМӨӨР АМ ХӨМӨӨМӨР НЭГЭЙН « ХӨМӨӨ ДАМ ХӨНӨННӨ АМ . ХӨНӨННӨ АМ 01306 АМА 6 Ө КӨМӨННӨ ХӨ ШӨ НЭМӨӨНӨГӨННӨМӨӨ ..
- 71 . ХӨМӨӨННӨ ХӨМӨӨР АМ ХӨМӨӨМӨР ХӨНӨННӨ А . НЭМӨӨМӨР ХӨНӨННӨ АМ ХӨНӨМӨР . ХӨНӨМӨР Ө ХӨМӨӨННӨННӨ А ДАМ ХӨМӨӨН НЭГЭЙН « ХӨМӨӨ ДАМ ХӨНӨННӨ АМ 01001 АМА 61 Ө КӨМӨННӨ ХӨ ШӨ НЭМӨӨНӨГӨННӨМӨӨ ..
- 70 . ХӨМӨӨННӨ АМ ХӨМӨӨННӨ А . ХӨМӨӨННӨННӨМӨӨ . ХӨНӨМӨР Ө ХӨМӨӨННӨННӨ А ДАМ ХӨМӨӨН НЭГЭЙН « ХӨМӨӨ ДАМ ХӨНӨННӨ АМ 01001 АМА 61 Ө КӨМӨННӨ ХӨ ШӨ НЭМӨӨНӨГӨННӨМӨӨ ..
- 0 . ХӨНӨННӨ Ө ХӨМӨӨННӨННӨ НЭГЭЙН « ХӨМӨӨ ДАМ ХӨНӨННӨ АМ . ХӨНӨННӨ АМ 01601 АМА 70 Ө КӨМӨННӨ ХӨ ШӨ НЭМӨӨНӨГӨННӨМӨӨ ..
- 1а . ХӨМӨӨН ДАМ ХӨМӨӨННӨННӨ А ДАМ ХӨМӨӨН НЭГЭЙН « ХӨМӨӨ ДАМ ХӨНӨННӨ АМ . ХӨНӨННӨ АМ 01601 АМА 0 Ө КӨМӨННӨ ХӨ ШӨ НЭМӨӨНӨГӨННӨМӨӨ ..
- 0 . ХӨМӨӨННӨННӨ ХӨМӨӨННӨННӨ ДАМ ХӨМӨӨН НЭГЭЙН « ХӨМӨӨ ДАМ ХӨНӨННӨ АМ . ХӨНӨННӨ АМ 01601 АМА 60 Ө КӨМӨННӨ ХӨ ШӨ НЭМӨӨНӨГӨННӨМӨӨ ..
- 7 . ХӨНӨННӨННӨ АМ ХӨНӨМӨР ХӨГӨМӨР ХӨНӨННӨННӨ ХӨА ХӨНӨННӨННӨ ХӨНӨМӨР ХӨНӨННӨ А ДАМ ХӨМӨӨН НЭГЭЙН « ХӨМӨӨ ДАМ ХӨНӨННӨ АМ . ХӨНӨННӨ АМ 6601 АМА 01 Ө КӨМӨННӨ ХӨ ШӨ НЭМӨӨНӨГӨННӨМӨӨ ..
- 0 . ХӨМӨӨН ДАМ ХӨМӨӨМӨР Ө ХӨМӨӨН НЭГЭЙН « ХӨМӨӨ ДАМ ХӨНӨННӨ АМ . ХӨНӨННӨ АМ 7601 АМА 6 Ө КӨМӨННӨ ХӨ ШӨ НЭМӨӨНӨГӨННӨМӨӨ ..
- 06 . ХӨНӨМӨР ДАМ ХӨНӨМӨР « ХӨМӨӨ ДАМ ХӨНӨННӨННӨ » ХӨНӨННӨННӨ АМ 601 Ө АМА 6 Ө КӨМӨННӨ ХӨ ШӨ НЭМӨӨНӨГӨННӨМӨӨ ..
- 66 . ХӨМӨӨННӨННӨ АМ ХӨМӨӨН НЭГЭЙН « ХӨМӨӨ ДАМ ХӨНӨННӨННӨ » ХӨНӨННӨННӨ АМ 601 Ө АМА 01 Ө КӨМӨННӨ ХӨ ШӨ НЭМӨӨНӨГӨННӨМӨӨ ..

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“12 дугаар зүйл. Хот, тосгон, бусад суурин, нийслэл хотын эдэлбэр газар

12.1. Хот, тосгон, бусад суурин, нийслэл хотын эдэлбэр газарт хот, тосгон, бусад суурины барилга байгууламж, үйлдвэр, уурхайн дэвсгэр газар, инженерийн дэд бүтэц, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламжийн газар, нийтийн эдэлбэрийн газар болон цаашид тэлж хөгжих нөөц газар хамаарна.

12.2. Нийтийн эдэлбэрийн газарт хот, тосгон, бусад суурины гудамж, талбай, зам, нийтийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг газар хамаарна.

12.3. Хот, тосгон, бусад суурин, нийслэл хотын эдэлбэр газар нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нутаг дэвсгэрээс Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2-т заасан тэг гортигоор хязгаарлагдана.

12.4. Нийслэл хот, түүний дагуул хот нь бүсчлэл бүхий эдэлбэр газартай байна.

12.5. Нийслэл хотын дагуул хотын эдэлбэр газар нь бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байж болох бөгөөд энэ тохиолдолд тухайн дагуул хотын эдэлбэр газарт газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газрын төлбөрийг дагуул хот байрлаж байгаа аймаг, сумын төсөвт төвлөрүүлнэ.

12.6. Энэ хуулийн 12.4-т заасан эдэлбэр газрын бүсчлэлийг Засгийн газраас тогтоосон шалгуур үзүүлэлтийг үндэслэн нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын төлбөрийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 9 дэх хэсэг:

“9.Тусгай хамгаалалттай газар нутаг, нийслэлийн ногоон бүсэд аж ахуйн зориулалтаар газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд стандартын шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламж барьсан бол газрын төлбөрийг хоёр дахин өсгөж тооцно.”

2/8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалт:

“13.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 39.1-д заасан чиглэлээр үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс нийслэл хотын эдийн засгийн тусгай бүсэд эзэмшиж, ашиглаж байгаа газрын төлбөрөөс эхний таван жилд 100 хувь, дараагийн гурван жилд 50 хувиар.”

3/8 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг:

“4.Нийслэлийн нутаг дэвсгэр дэх ногоон бүсэд газар эзэмшиж, ашиглаж буй иргэн энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад заасан газрын төлбөрийн хөнгөлөлтийг эдлэхдээ стандартын шаардлагад нийцээгүй нүхэн жорлонгүй байх нөхцөлийг хангасан байна.

5.Газрын төлбөрөөс хөнгөлөгдөж, чөлөөлөгдсөн иргэн, хуулийн этгээд газрыг зориулалтын дагуу эзэмшиж, ашиглаагүй нь тогтоогдвол хөнгөлж, чөлөөлсөн газрын төлбөрийг төсөвт нөхөн төлүүлнэ.”

4/9 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг:

“7.Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасан газрын төлбөрийг хоёр дахин нэмэгдүүлж ногдуулах, 8 дугаар зүйлийн 4 дэх заалтад заасан газрын төлбөрийн хөнгөлөлт эдлүүлэх журмыг Нийслэлийн Засаг дарга, газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын болон татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга нар хамтран батална.”



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.6 дахь заалт нэмсүгэй:

“7.1.6.нийслэл хотын тусгай бүсэд бүртгэгдсэн барилга байгууламж.”

2 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “0.6-1.0” гэснийг “0.6-2.0” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.1.2.иргэн, хуулийн этгээдийн өмчилж байгаа аймаг, суман дахь орон сууц, нийслэл дэх хоёр орон сууц;”

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
ХОТ

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсгийн “27 дугаар зүйлд” гэснийг “27 дугаар зүйл, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8.2-т” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Үсэнтүгэй Мөмбөр, Эр Сайн

Мэргэжлийн Зөвлөл, Эр Сайн 2009 - 09 - 09

Мэргэжлийн Зөвлөл, Эр Сайн
Мэргэжлийн Зөвлөл

6 Кэрийн Зөвлөл, Мэргэжлийн Зөвлөл, Эр Сайн 2009 - 09 - 09
Эр Сайн 2009 - 09 - 09
Мэргэжлийн Зөвлөл, Эр Сайн 2009 - 09 - 09
Мэргэжлийн Зөвлөл, Эр Сайн 2009 - 09 - 09

7 Кэрийн Зөвлөл, Мэргэжлийн Зөвлөл, Эр Сайн 2009 - 09 - 09
Эр Сайн 2009 - 09 - 09
Мэргэжлийн Зөвлөл, Эр Сайн 2009 - 09 - 09
Мэргэжлийн Зөвлөл, Эр Сайн 2009 - 09 - 09

Мэргэжлийн Зөвлөл, Эр Сайн
Эр Сайн 2009 - 09 - 09

Эр Сайн 2009 - 09 - 09

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Өрийн удирдлагын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.24 дэх заалт:

“4.1.24.“аймаг, нийслэлийн үнэт цаас” гэж аймаг, нийслэлээс тодорхой төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэх, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зорилгоор хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл, журмын дагуу дотоодын зах зээлд олон нийтэд санал болгон, эсхүл нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд арилжаалах өрийн бичгийг.”

2/28¹ дүгээр зүйл:

“28¹ дүгээр зүйл.Аймаг, нийслэл үнэт цаас гаргах

28¹.1.Аймаг, нийслэл нь тодорхой төсөл, арга хэмжээ, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зорилгоор үндэсний мөнгөн тэмдэгтээр дотоодын зах зээлд үнэт цаас гаргаж болно.

28¹.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь тухайн аймаг, нийслэлийн нэрийн өмнөөс үнэт цаас гаргагчийн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

28¹.3.Энэ хуулийн 28¹.1-д заасан төсөл, арга хэмжээ нь энэ хуулийн 18.5.1, 18.5.2, 18.5.3, 18.5.4-т заасан шаардлагыг хангасан байна.

28¹.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга үнэт цаас гаргах тухай саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах бөгөөд дэмжсэн шийдвэр гарсан тохиолдолд төсвийн жил эхлэхээс дөрвөөс доошгүй сарын өмнө санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж дүгнэлт гаргуулна.

28¹.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аймаг, нийслэлийн Засаг даргын үнэт цаас гаргах шийдвэрийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан хязгаар болон хуульд заасан нөхцөл, шаардлага, шалгуур үзүүлэлтэд нийцсэн болохыг тогтоосон тохиолдолд жилийн төсвийн төслийг Засгийн газарт

өргөн мэдүүлэхээс өмнө үнэт цаас гаргах шийдвэрийн төслийг Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлнэ.

28¹.6.Аймаг, нийслэлийн үнэт цаас гаргахад энэ хуулийн 19.1-д заасныг удирдлага болгох бөгөөд дараах шаардлагыг бүрэн хангасан байна:

28¹.6.1.Засгийн газраас үнэт цаас гаргах тухай зөвшөөрөл авсан байх;

28¹.6.2.Засгийн газрын шинээр үүсгэх өрийн дээд хэмжээнд нийцсэн байх;

28¹.6.3.Засгийн газрын өрийн удирдлагын стратегийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, зээллэгийн төлөвлөгөөнд нийцсэн, аймаг, нийслэлийн төсвийн төсөлд үнэт цаасаар хүлээх үүргийн хэмжээ, үнэт цаас гаргахтай холбогдсон зардлыг тусгасан байх;

28¹.6.4.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын энэ хуулийн 16.2-т заасны дагуу гаргасан дүгнэлт нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан хязгаар болон хуульд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтэд нийцсэн болохыг тогтоосон байх;

28¹.6.5.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах тухай Засаг даргын саналыг дэмжсэн байх;

28¹.6.6.хууль тогтоомжид заасан бусад.

28¹.7.Аймаг, нийслэлийн Засаг даргын үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэхтэй холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулан, Засгийн газар баталж мөрдүүлнэ.

28¹.8.Аймаг, нийслэлийн үнэт цаасны төлбөрийг улсын төсвийн шилжүүлэг болон дэмжлэгээр төлөхийг хориглоно.

28¹.9.Энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг зөрчиж аймаг, нийслэлийн үнэт цаас гаргахыг хориглоно.

2 дугаар зүйл.Өрийн удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.3 дахь заалтын “зохион байгуулах” гэсний дараа “, аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах” гэж, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “19” гэсний дараа “28” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “6.2.2” гэсний



өмнө “28’ дүгээр зүйл” гэж, 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсгийн “Засгийн газрын” гэсний дараа “болон аймаг, нийслэлийн” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Өрийн удирдлагын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “19.11-д” гэснийг “19.11, 28’ дүгээр зүйлийн 28’1.8, 28’1.9-т” гэж, “32 дугаар зүйлд гэснийг “35.1.7 дахь заалтад” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

ҮНДЭМЖ БИЧИГЭЭНИЙН ТУХАЙ

Бичигдсэн үсгийн дугаар 67070
 67070 үсэг 9 болон 10-д оруулсан үсгийн дугаар 67070
 . үндсэн хуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “19.11-д” гэснийг “19.11, 28’ дүгээр зүйлийн 28’1.8, 28’1.9-т” гэж, “32 дугаар зүйлд гэснийг “35.1.7 дахь заалтад” гэж өөрчилсүгэй.

6 дүгээр зүйл .. үндсэн хуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “19.11-д” гэснийг “19.11, 28’ дүгээр зүйлийн 28’1.8, 28’1.9-т” гэж, “32 дугаар зүйлд гэснийг “35.1.7 дахь заалтад” гэж өөрчилсүгэй.

9 / 6 дүгээр зүйл .. үндсэн хуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “19.11-д” гэснийг “19.11, 28’ дүгээр зүйлийн 28’1.8, 28’1.9-т” гэж, “32 дугаар зүйлд гэснийг “35.1.7 дахь заалтад” гэж өөрчилсүгэй.

» 970 . 6 . 0 » үндсэн хуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “19.11-д” гэснийг “19.11, 28’ дүгээр зүйлийн 28’1.8, 28’1.9-т” гэж, “32 дугаар зүйлд гэснийг “35.1.7 дахь заалтад” гэж өөрчилсүгэй.

үндсэн хуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “19.11-д” гэснийг “19.11, 28’ дүгээр зүйлийн 28’1.8, 28’1.9-т” гэж, “32 дугаар зүйлд гэснийг “35.1.7 дахь заалтад” гэж өөрчилсүгэй.

үндсэн хуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “19.11-д” гэснийг “19.11, 28’ дүгээр зүйлийн 28’1.8, 28’1.9-т” гэж, “32 дугаар зүйлд гэснийг “35.1.7 дахь заалтад” гэж өөрчилсүгэй.

үндсэн хуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “19.11-д” гэснийг “19.11, 28’ дүгээр зүйлийн 28’1.8, 28’1.9-т” гэж, “32 дугаар зүйлд гэснийг “35.1.7 дахь заалтад” гэж өөрчилсүгэй.

үндсэн хуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “19.11-д” гэснийг “19.11, 28’ дүгээр зүйлийн 28’1.8, 28’1.9-т” гэж, “32 дугаар зүйлд гэснийг “35.1.7 дахь заалтад” гэж өөрчилсүгэй.

үндсэн хуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “19.11-д” гэснийг “19.11, 28’ дүгээр зүйлийн 28’1.8, 28’1.9-т” гэж, “32 дугаар зүйлд гэснийг “35.1.7 дахь заалтад” гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалтыг нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.1.10 дахь заалт:

“5.1.10. Аймаг, нийслэлийн үнэт цаас;”

2/9 дүгээр зүйлийн 9.18 дахь хэсэг:

“9.18. Аймаг, нийслэлийн үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах бол Санхүүгийн зохицуулах хороонд хялбаршуулсан журмаар бүртгүүлэх бөгөөд үүнтэй холбоотой журмыг Хороо батална.”

3/10 дугаар зүйлийн 10.15.6 дахь заалт:

“10.15.6. Аймаг, нийслэлийн үнэт цаас гаргах;”

2 дугаар зүйл. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “Засгийн газар,” гэсний дараа “аймаг, нийслэл,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтын “тэмдэгжүүлж,” гэсний дараа “хамгаалах, тохижуулах,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Уснийг хамгаалах тухай хууль

Уснийг хамгаалах тухай хууль /2010 оны 07 сарын 07-ны өдөр /

Уснийг хамгаалах тухай хууль

Уснийг хамгаалах тухай хууль /2010 оны 07 сарын 07-ны өдөр /

Уснийг хамгаалах тухай хууль /2010 оны 07 сарын 07-ны өдөр /

Уснийг хамгаалах тухай хууль

Уснийг хамгаалах тухай хууль /2010 оны 07 сарын 07-ны өдөр /



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/35 дугаар зүйлийн 35.1.4-35.1.22 дахь заалт:

“35.1.4.агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 200 000-1 000 000 төгрөг;

35.1.5.тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгоход 100 000-500 000 төгрөг;

35.1.6.ус хэрэглэгчид газрын доорх ус ашиглалтын цооног өрөмдөх зөвшөөрөл олгоход 96 000-480 000 төгрөг;

35.1.7.ус ашиглагчтай гэрээ байгуулж, 100 шоо метрээс бага ус ашиглуулах гэрчилгээ олгоход гэрээний жил тутамд 32 000-160 000 төгрөг, гэрээг сунгахад 20 000-100 000 төгрөг;

35.1.8.усны барилга байгууламж гэрээгээр эзэмших, ашиглах эрх олгох, эрх сунгахад 40 000-200 000 төгрөг;

35.1.9.ан амьтныг эзэмших зөвшөөрөл олгоход 48 000-240 000 төгрөг;

35.1.10.нэн ховор, ховор амьтныг судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, гоо зүйн зориулалтаар /ажиглаж судлах, тэмдэг тавих, зурах, зураг авах зэрэг хэлбэрээр/ амьтныг гэмтээлгүйгээр амьдрах орчныг нь алдагдуулалгүйгээр ашиглах зөвшөөрөл олгоход 40 000-200 000 төгрөг;

35.1.11.хөрс бүрдүүлэх, байгалийг ариутгах, ургамалд тоос хүртээх зэрэгт амьтны амьдралын үйл ажиллагааны хэрэгтэй чанарыг ашиглахдаа амьтанд гэмтэл учруулахгүйгээр гүйцэтгэх ба ийм хэлбэрээр амьтныг ашиглах зөвшөөрлийг олгоход 8000-40 000 төгрөг;

35.1.12.ан амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, хуулийн этгээдэд суман дахь байгаль хамгаалагч гарал үүслийн тодорхойлолт олгоход 1000-10 000 төгрөг;

35.1.13. үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын ан амьтан агнах, барих гэрээ байгуулахад 400 000-2 000 000 төгрөг;

35.1.14. мал бүхий иргэн, хуулийн этгээдээс төв суурин газарт борлуулах зорилгоор оруулж байгаа олон тооны мал, мах бэлтгэхэд гарал үүслийн гэрчилгээ олгоход 0-10 толгой мал бол 1000-10000 төгрөг, 10-аас дээш тооны толгой мал бол 1000-10000 төгрөг дээр 10-аас дээш тооны малын толгой тутамд 50-200 төгрөг нэмж;

35.1.15. ховор ургамлыг ахуйн болон судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход килограмм тутамд 1200-6000 төгрөг;

35.1.16. элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход 1000-4000 төгрөг;

35.1.17. элбэг ургамлыг гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд түүж бэлтгэхэд нойтон жингийн килограмм тутамд 4000-20000 төгрөг;

35.1.18. ойн дагалт нөөцийг ашиглах эрхийн бичиг олгоход 0-10 килограмм бол 1000-4000 төгрөг, 10 килограммаас дээш бол 10 килограммаас дээш тооцсон хэмжээний килограмм тутамд 50-200 төгрөг нэмж;

35.1.19. мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг хувиараа эрхлэх, малын үр, үр хөврөл, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн нутагт явуулахад зохих байгууллагын дүгнэлтийг үндэслэн хуулийн этгээдэд олгоход 200 000-1 000 000 төгрөг, иргэнд 160 000-800 000 төгрөг;

35.1.20. мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг хувиараа эрхлэх, малын үр, үр хөврөл, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэл үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сум, дүүргийн нутагт явуулахад зохих байгууллагын дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга олгоход 80 000-400 000 төгрөг;

35.1.21. мал, түүний үржлийн чанар, ашиг шим, эрүүл мэнд болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд үзлэг, шинжилгээ хийж гарал үүсэл, чанарыг тодорхойлон гэрчилгээ олгоход 2000-10000 төгрөг;

35.1.22. рашаан ашиглах, савлах зөвшөөрөл олгоход 125 000-640 000 төгрөг.”



2/35 дугаар зүйлийн 35.2.1-35.2.4 дэх заалт:

“35.2.1.спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход нийслэлд 400 000-2 000 000 төгрөг, аймгийн төвийн суманд 240 000-1 200 000 төгрөг, бусад суманд 120 000-600 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад нийслэлд 120 000-600 000 төгрөг, аймгийн төвийн суманд 80 000-400 000 төгрөг, бусад суманд 40 000-200 000 төгрөг;

35.2.2.спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход нийслэлд 120 000-600 000 төгрөг, аймгийн төвийн суманд 80 000-400 000 төгрөг, бусад суманд 40 000-200 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад нийслэлд 40 000-200 000 төгрөг, аймгийн төвийн суманд 30 000-140 000 төгрөг, бусад суманд 16 000-80 000 төгрөг;

35.2.3.спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход нийслэлд 600 000-3 000 000 төгрөг, аймгийн төвийн суманд 320 000-1 600 000 төгрөг, бусад суманд 200 000-1 000 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад нийслэлд 200 000-1 000 000 төгрөг, аймгийн төвийн суманд 160 000-800 000 төгрөг, бусад суманд 80 000-400 000 төгрөг;

35.2.4.спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход нийслэлд 300 000-1 500 000 төгрөг, аймгийн төвийн суманд 160 000-800 000 төгрөг, бусад суманд 100 000-500 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад нийслэлд 160 000-800 000 төгрөг, аймгийн төвийн суманд 80 000-400 000 төгрөг, бусад суманд 50 000-240 000 төгрөг.”

3/35 дугаар зүйлийн 35.6.1 дэх заалт:

“35.6.1.түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр хайгуулын талбайн гектар тутамд эхний жилд 200 төгрөг, хоёр дахь жилд 400 төгрөг, гурав дахь жилд 600 төгрөг, дөрвөөс тав дахь жилд тус бүр 2000 төгрөг;”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙСЛЭЛ ХОТЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийслэл хотын албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.8, 4.1.9 дэх заалт:

“4.1.8.”автомашин угаалгын газар” гэж автомашины бохирдлыг цэвэрлэх иж бүрэн үйлчилгээ үзүүлэх байгууламжийг;

4.1.9.“авто үйлчилгээ үзүүлэгч” гэж нийтийн тээврээс бусад автотээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдсон үйлчилгээг үзүүлэх иргэн, аж ахуйн нэгжийг.”

2/7 дугаар зүйлийн 7.2.5, 7.2.6 дахь заалт:

“7.2.5.энэ хуулийн 4.1.8-д заасан үйлчилгээ;
7.2.6.энэ хуулийн 4.1.9-д заасан үйлчилгээ.”

2 дугаар зүйл.Нийслэл хотын албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “4.1.3-т” гэснийг “4.1.3, 4.1.8, 4.1.9-д” гэж, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал” гэснийг “нийслэлийн Засаг дарга, татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга хамтран” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “0-1.0” гэснийг “0-2.0” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН АВТОТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь хэсэг нэмсүгэй:

“3.Албан татвар ногдох автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх, бүртгэлээс хасах журмыг татвар, гааль, зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран батална.”

2 дугаар зүйл. Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1.Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг дараах хэмжээгээр ногдуулна:

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн төрөл		Жилд ногдуулах албан татварын дээд, доод хязгаар /төгрөгөөр/	
		Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймгийн төвийн сумд	Бусад сумд
1	2 дугуйтай мотоцикл	2 000-6 000	1 800-5 400
2	3 дугуйтай мотоцикл	1 500-9 000	2 800-8 400
3	Суудлын автомашин: а/ 2001 см ³ хүртэл б/ 2001-3001 см ³ хүртэл в/ 3001 см ³ болон түүнээс дээш	/Цилиндрийн багтаамжийн нэг см ³ тутамд төгрөгөөр/ 16-48 18-54 22-66	14-42 16-48 20-60
4	Микроавтобус /15 хүртэл суудалтай/	35 000-105 000	28 000-84 000
5	Автобус	52 000-156 000	40 000-120 000



6	Ачааны автомашин: 1/ 1 хүртэл тн-ын даацтай	25 000-75 000	20 000-60 000
	2/ 1-2 тн-ын даацтай	35 000-105 000	28 000-84 000
	3/ 2-3 тн-ын даацтай	45 000-135 000	36 000-108 000
	4/ 3-5 тн-ын даацтай	55 000-165 000	44 000-132 000
	5/ 5-8 тн-ын даацтай	80 000-240 000	64 000-192 000
	6/ 8-10 тн-ын даацтай	90 000-270 000	72 000-216 000
	7/ 10-20 тн-ын даацтай	100 000-300 000	80 000-240 000
	8/ 20-30 тн-ын даацтай	120 000-420 000	120 000-360 000
	9/ 30-40 тн-ын даацтай	180 000-540 000	180 000-480 000
	10/ 40-50 тн-ын даацтай	220 000-660 000	200 000-600 000
	11/ 50-60 тн-ын даацтай	280 000-840 000	240 000-720 000
	12/ 60-70 тн-ын даацтай	320 000-960 000	280 000-840 000
	13/ 70-80 тн-ын даацтай	360 000-1 080 000	320 000-960 000
	14/ 80-90 тн-ын даацтай	400 000-1 200 000	380 000-1 140 000
	15/ 90-100 тн-ын даацтай	440 000-1 320 000	420 000-1 260 000
	16/ 100 тн-оос дээш даацтай	480 000-1 440 000	440 000-1 320 000
7	Тусгай зориулалтын автомашин	16 000-48 000	15 000-45 000
8	Трактор, өөрөө явагч бусад хэрэгсэл	14 000-42 000	11 200-33 600
9	Бага оврын трактор	7 000-21 000	5 600-16 800
10	Чиргүүл /даацын 1 тонн тутамд/	5 500-16 500	5 500-16 500

3 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг:

“12.3.Суурьшлын болон ногоон бүсээс 1 км дотор түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хориглоно.”

2/17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэг:

“17.4.Суурьшлын болон ногоон бүсээс 1 км дотор түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохыг хориглоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Үсэнтэйг бичгээр хүлээн

61010 Уср 9 00 Км-ийн тусгай бүсэд
Монгол Улсын Ерөнхийлөгч

Монгол Улсын Ерөнхийлөгч
Улаанбаатар хот

6 Км-ийн бүсэд .. Монгол Улсын Ерөнхийлөгч
Монгол Улсын Ерөнхийлөгч /Монгол Улсын Ерөнхийлөгч
Монгол Улсын Ерөнхийлөгч

6 / 06 Км-ийн бүсэд 06 / 06 Км-ийн бүсэд :

« 06 / 06 Км-ийн бүсэд .. Монгол Улсын Ерөнхийлөгч
Монгол Улсын Ерөнхийлөгч /Монгол Улсын Ерөнхийлөгч
Монгол Улсын Ерөнхийлөгч

06 / 06 Км-ийн бүсэд 06 / 06 Км-ийн бүсэд :

« 06 / 06 Км-ийн бүсэд .. Монгол Улсын Ерөнхийлөгч
Монгол Улсын Ерөнхийлөгч /Монгол Улсын Ерөнхийлөгч
Монгол Улсын Ерөнхийлөгч

06 / 06 Км-ийн бүсэд .. Монгол Улсын Ерөнхийлөгч
Монгол Улсын Ерөнхийлөгч /Монгол Улсын Ерөнхийлөгч
Монгол Улсын Ерөнхийлөгч

Монгол Улсын Ерөнхийлөгч
Улаанбаатар хот



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.7 дахь хэсэг нэмсүгэй:

“12.7.Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь иргэн, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгосон, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тухай мэдээллийг шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарснаас хойш ажлын долоон өдрийн дотор харьяа татварын албанд хүргүүлнэ.”

2 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт “Тусгай зөвшөөрөл хүсэгч нь татварын өргүй, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлд заасан цахим төлбөрийн баримтын системд холбогдсон байна.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

ҮСНИЙН БИЧИГЭР

6᠓᠐᠐᠐ - ᠘᠐᠐᠐᠐ КМН БН А ДМ ᠘᠐ - ᠙᠐
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ, АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

᠖ КМН АМН .. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ, АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ, АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ, АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

᠒᠐᠒᠑ . ᠙ . ᠑᠗ . МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ, АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ, АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ, АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ, АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ, АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

᠓᠐᠐᠐᠐ - ᠘᠐᠐᠐᠐ КМН БН А ДМ ᠘᠐ - ᠙᠐
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ, АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ, АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ, АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ, АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

᠓᠐᠐᠐᠐ - ᠘᠐᠐᠐᠐ КМН БН А ДМ ᠘᠐ - ᠙᠐
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ, АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ, АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ, АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ, АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ, АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУУЛЬ, АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.10 дахь заалтын “Нийслэлийн” гэснийг “нийслэл хотын” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Үсчиндэмжирмэр гэр үсчин

Үсчиндэмжирмэр гэр үсчин 6000 - 00 км-н үсчиндэмжирмэр гэр үсчин

Үсчиндэмжирмэр гэр үсчин 6000 - 00 км-н үсчиндэмжирмэр гэр үсчин

6 км-н үсчиндэмжирмэр гэр үсчин 6000 - 00 км-н үсчиндэмжирмэр гэр үсчин

7 км-н үсчиндэмжирмэр гэр үсчин 6000 - 00 км-н үсчиндэмжирмэр гэр үсчин

Үсчиндэмжирмэр гэр үсчин

Үсчиндэмжирмэр гэр үсчин



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙСЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.1994 оны 7 дугаар сарын 5-ны өдөр баталсан Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Үсчингүйд хууль

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ ХУУльд НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, заалт нэмсүгэй:

1/8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт:

“8.1.4.хотын стандарт.”

2/10¹ дүгээр зүйл.Хотын стандарт

“10¹.1.Хотын удирдлагаас иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах чиг үүргийнхээ хүрээнд стандарт батлан хэрэгжүүлж болно.

10¹.2.Хотын стандарт нь үндэсний стандарт, техникийн зохицуулалтын үзүүлэлт, шаардлагад нийцсэн байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Үргэлжлэлт хуулийн

610101 хууль 09 нэмэлт хууль - 9 нэмэлт үргэлжлэлт хууль

0 нэмэлт хууль, хуулийн төслийн үндсэн дээр үргэлжлэлт хууль батлах

6 хуулийн төслийн үндсэн дээр үргэлжлэлт хууль батлах, хуулийн төслийн үндсэн дээр үргэлжлэлт хууль батлах:

7 /6 нэмэлт хууль батлах үндсэн дээр үргэлжлэлт хууль батлах:

« 0 . 6 . 7 . 0 . 0 . 6 . 7 »

06 /7 нэмэлт хууль батлах үндсэн дээр үргэлжлэлт хууль батлах

« 06 . 06 . 06 » нэмэлт хууль батлах үндсэн дээр үргэлжлэлт хууль батлах, хуулийн төслийн үндсэн дээр үргэлжлэлт хууль батлах:

06 . 06 . 06 нэмэлт хууль батлах үндсэн дээр үргэлжлэлт хууль батлах, хуулийн төслийн үндсэн дээр үргэлжлэлт хууль батлах:

07 нэмэлт хууль батлах үндсэн дээр үргэлжлэлт хууль батлах, хуулийн төслийн үндсэн дээр үргэлжлэлт хууль батлах:

үргэлжлэлт хууль батлах үндсэн дээр үргэлжлэлт хууль батлах, хуулийн төслийн үндсэн дээр үргэлжлэлт хууль батлах:



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 68

Улаанбаатар
хот

“Хот байгуулах тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 55 дугаар тогтоолын 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2.“Шинэ Зуунмод” болон “Майдар” хотуудыг байгуулахдаа Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Төв аймгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигтэй уялдуулан холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулан шийдвэрлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.”

2.Энэ тогтоолыг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 06 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 208

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Зэвсэгт хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.15 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. “Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү журмыг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга дэслэгч генерал Д.Ганзориг нарт тус тус үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын яам /сайд Г.Сайханбаяр/-нд даалгасугай.

4. Журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад эрх зүйн баримт бичгүүдийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, мөрдөж ажиллахыг Батлан хамгаалах яам /сайд Г.Сайханбаяр/, Зэвсэгт хүчний Жанжин штаб /дэслэгч генерал Д. Ганзориг/-т тус тус зөвшөөрсүгэй.

5. Энэ зарлиг батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны
06 дугаар сарын 24-ний өдрийн 208 дугаар
зарлигийн хавсралт

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БИЕ БҮРЭЛДЭХҮҮН, ТЕХНИК ХЭРЭГСЛИЙГ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛД ОРОЛЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалт /цаашид “Бүтээн байгуулалт” гэх/ болон улс орны нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий аж ахуйн ажил /цаашид “Аж ахуйн ажил” гэх/-д оролцуулах үйл ажиллагаа, үүнтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэ журам нь бүтээн байгуулалтад Зэвсэгт хүчнийг оролцуулах зарчим, чиглэл, оролцоо, шийдвэр гаргах тогтолцоо, дараалал, бүх талын хангалт, байгууллагуудын хүлээх үүрэг, хариуцлага, харилцан ажиллах үндсийг тодорхойлсон баримт бичиг мөн.

Хоёр. Нэр томьёоны тодорхойлолт

2.1. Энэ журамд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. “Бүтээн байгуулалт” гэж улсыг хөгжүүлэх гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай стратегийн ач холбогдол бүхий үйлдвэрлэл, дэд бүтэц, барилга байгууламж барих төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, цэргийн дэд бүтцийг хөгжүүлэх, улсын болон цэргийн онц чухал объектуудыг барьж байгуулах, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэх, инновацын судалгаа, туршилт, үйлдвэрлэл, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, экосистемийг сэргээн босгох үйл ажиллагааг;

2.1.2. “Аж ахуйн ажил” гэж Монгол Улсын төрийн ба хувийн хэвшлийн зам, тээвэр, барилга, эрчим хүч, уул уурхай, хүнс, хөдөө аж ахуйн салбарт дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хэлнэ.

Гурав. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг бүтээн байгуулалтын ажилд оролцуулахад баримтлах зарчим

3.1.Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын бэлэн байдлыг алдагдуулахгүй байх;

3.2. Бүтээн байгуулалтын ажлын төлөвлөлт, хэрэгжилт нь хууль тогтоомжийн хүрээнд улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, Монгол Улсын Батлан хамгаалах бодлого, зорилт, Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги, Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх хөтөлбөртэй нийцсэн байх;

3.3. Инновацад суурилсан инженерийн шийдлийг нэвтрүүлэх, техник хэрэгслийг шинэчлэх, нөөцийг бүрдүүлэх, анги, салбаруудын чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байх;

3.4. Эрх зүйн орчин бүрдсэн, нэгдмэл удирдлага, зохион байгуулалттай, хяналт-шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ, санхүүжилтийн механизмтай байх;

3.5. Цэргийн алба хаагч, ажилчин албан хаагчдын ажиллах ая тухтай орчныг бүрдүүлж, хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган, техник, технологийн ослоос урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдсэн байх;

3.6. Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнийг Зэвсэгт хүчний тухай хууль болон энэхүү журамд зааснаас бусад ажилд оролцуулахгүй байх зарчмыг баримтална.

Дөрөв. Бүтээн байгуулалтын ажилд оролцох хүч хэрэгсэл

4.1. Бүтээн байгуулалтын ажилд оролцох үндсэн хүч хэрэгсэл нь Барилга-инженерийн цэрэг, Зэвсэгт хүчний төрөл, тусгай мэргэжлийн бусад цэргээс татан оролцуулж байгаа бие бүрэлдэхүүн, техник хэрэгслээс бүрдэнэ.

4.2. Зэвсэгт хүчин нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагыг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр хууль, эрх зүйн хүрээнд сонгон шалгаруулж бүтээн байгуулалтын ажилд туслан гүйцэтгэгчээр ажиллуулж болно.

4.3. Зэвсэгт хүчин нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагатай үйл ажиллагааны чиглэлээр хамтран ажиллаж болно.

4.4. Зэвсэгт хүчин нь Цэргийн гадаад хамтын ажиллагаа, энхийг дэмжих ажиллагааны чиглэлээр бусад орны цэргийн хүчний ижил төстэй байгууллагатай хамтран ажиллана.

Тав. Бүтээн байгуулалтын ажилд оролцуулах шийдвэр гаргах журам, дараалал

5.1. Монгол Улсын Засгийн газар Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг бүтээн байгуулалтад оролцуулах хүсэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчид гаргаж, түүний зөвшөөрлийг үндэслэн бүтээн байгуулалтын ажилд оролцуулах шийдвэр гаргана.

5.2. Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга журмын 2.1.2-т заасан аж ахуйн ажилд Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг оролцуулах асуудлыг Батлан хамгаалахын сайдад танилцуулан, Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчид хүсэлт гаргаж, жил бүр зөвшөөрөл авна.

5.3. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч журмын 2.1.1, 2.1.2-т заасан ажилтай холбогдуулан холбогдох албан тушаалтны мэдээлэл, хүсэлтийг сонсож, зөвшөөрөл олгоно.

5.4. Энэ журмын 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан шийдвэрт бүтээн байгуулалтын ажилд Зэвсэгт хүчнээс оролцох бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийн тоо, гүйцэтгэх үүрэг, хугацаа, төсөв, ажлын цар хүрээ, цалин хангамж, техник хэрэгслийн түрээсийн төлбөр, ашиглалтын зардлыг тусгана.

5.5. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн зөвшөөрөл, Засгийн газрын шийдвэр, Батлан хамгаалахын сайдын тушаалыг үндэслэн Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар бүтээн байгуулалтын болон аж ахуйн ажилд Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг томилон ажиллуулна.

Зургаа. Бүтээн байгуулалтын ажилд оролцох бүрэлдэхүүнийг бэлтгэх

6.1. Батлан хамгаалахын төрийн захиргааны төв байгууллага нь бүтээн байгуулалтын ажилтай холбогдуулан төрийн байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулж, бие бүрэлдэхүүний томилолт болон техник хэрэгслийн түрээсийн төлбөрийн хэмжээг тогтооно.

6.2. Зэвсэгт хүчний Жанжин штаб, Төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын дарга, захирагч нар бүтээн байгуулалтын ажилд оролцох бүрэлдэхүүний бэлтгэлийг удирдан зохион байгуулж, хангуулна.

6.3. Бүтээн байгуулалтын болон аж ахуйн ажил гүйцэтгэх гэрээнд талуудын эрх үүрэг, хариуцлага, ажлын цар хүрээ, хэмжээ, хугацаа, бие бүрэлдэхүүний ажлын хөлс, хангалт, томилолтын зардал, техник хэрэгслийн ашиглалтын зардал, аюулгүй ажиллагааны нөхцөл, хяналт шалгалт, гэрээг дүгнэх асуудлыг тусгана.

6.4. Гэрээ байгуулсан талууд цэргийн алба хаагч, ажилтан албан хаагчдын ажиллах ая тухтай орчныг бүрдүүлж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцлийг ханган, техник, технологийн ослоос урьдчилан сэргийлэх талаар хамтарч ажиллана.

6.5. Бүтээн байгуулалтын ажлын удирдлага холбоо, мэдээллийн системийг Зэвсэгт хүчин бие дааж болон харилцаа холбооны байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээний дагуу зохион байгуулна.

Долоо. Бүтээн байгуулалтын ажилд оролцуулах, дүн гаргах

7.1. Бүтээн байгуулалтын ажилд оролцож байгаа бие бүрэлдэхүүнийг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар томилогдсон Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, албан тушаалтан удирдана.

7.2. Журмын 8.1-д заасан байгууллага, албан тушаалтнууд хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурж, гэрээ хүчин төгөлдөр болсноор томилгоот бүрэлдэхүүнийг бүтээн байгуулалтын ажилд оролцуулна.

7.3. Бүтээн байгуулалтын ажил, ажлын цар хүрээ, хэмжээ, хугацаа, оролцох бие бүрэлдэхүүнээс хамаарч бүтээн байгуулалтын түр орон тоо байгуулж болно.

7.4. Бүтээн байгуулалтын ажилд оролцож байгаа Зэвсэгт хүчний бүрэлдэхүүний ажлын гүйцэтгэлд хяналт, шалгалт явуулж болно. Бүтээн байгуулалтын ажлын явц байдал, биелэлтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал, шалгуур үзүүлэлтийг урьдчилан боловсруулж, мөрдөнө.

7.5. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, гэрээний гүйцэтгэлийн дүнг нотломжоор үйлдэж, гарын үсэг зурснаар тухайн ажлыг дуусгавар болсонд тооцон, гэрээний хэрэгжилтийг дүгнэнэ.

7.6. Төрлийн цэргийн командлал, удирдах газар, цэргийн нэгтгэл, анги, байгууллагын дарга, захирагч нар өөрийн чиг үүргийн хүрээнд бүрэлдэхүүнээ бүтээн байгуулалтын ажилд бэлтгэн оролцуулж, шаардагдах хангалт, үйлчилгээг зохион байгуулж, дүнг тогтоосон хугацаанд дээд байгууллагуудад хүргүүлж байна.

7.7. Бүтээн байгуулалтын ажлыг удирдахаар томилогдсон албан тушаалтан Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын зөвлөлд ажлын гүйцэтгэлийн талаар танилцуулна.

7.8. Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга бүтээн байгуулалтын ажилд Зэвсэгт хүчний бүрэлдэхүүн, техник хэрэгслийг оролцуулсан тухай дүнг Батлан хамгаалахын сайд, Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчид танилцуулна.

Найм. Бусад зүйл

8.1. Журмын 2.1.1-д заасан бүтээн байгуулалтын үйл ажиллагааны орлогыг “Зэвсэгт хүчний хөгжлийн сан”-д төвлөрүүлнэ.

8.2. Журмын 2.1.2-т заасан ажлаас олсон орлогыг Зэвсэгт хүчний төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, ажлын үр дүнг тооцон зарцуулна.

8.3. Улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтад цэргийн анги, салбар, нэгжийг оролцуулснаас олсон төлөвлөх боломжгүй орлогыг Зэвсэгт хүчний тухай хуулийн 18¹ дүгээр зүйлийн 18¹.5 дахь хэсэгт заасны дагуу захиран зарцуулна.

8.4. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 6.25

Индекс: 200003